



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А188

Мандалговь

“Яг одоо хүчирхийллийг цэглэе”  
16 хоногийн аянд нэгдэх тухай

Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.7, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийнхээ төлөө “Яг одоо хүчирхийллийг цэглэе” уриан дор охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй аливаа хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнд нэгдэх зорилгоор “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулсугай.

2. “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы нөлөөллийн зурагт самбарын төсвийг хавсралтаар баталсугай.

3. “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-д зарцуулагдах 56000 (Тавин зургаан мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн санхүүжилтээс зарцуулахыг нягтлан бодогч (С. Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг ханган, тайлагнаж ажиллахыг Хамгаалах байрны ажилтан (Э.Шинэхүү)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хамгаалах байрны ажилтан (Э.Шинэхүү)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

81190277

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2020 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн  
А/38 тоот тушаалын 01 дугаар хавсралт



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯНД  
НЭГДЭХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Хэрэглэгдэхүүн	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Тоо	Нийт үнэ
1	Хөөсөн хавтан	1.20*80	24000	1	24000
2	Хөөсөн хавтан /жижиг/	А3	3000	4	12000
3	Хэвлэл	1.80*80	20000	1	20000
<b>Нийт</b>					<b>56.000</b>